



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/682

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд “Төв сайхан нутаг-100” хүндэтгэлийн тоглолтыг Улаанбаатар хотод 2022 оны 12 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагааны зардал 3,532,400 (гурван сая таван гучин хоёр мянга дөрвөн зуу) төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), шилэн дансанд байршуулахыг аймгийн Ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

